



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/25

Чойр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2022 оны аймгийн “Авто замын сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Аймгийн төвийн авто замын дагуу тэмдэг, тэмдэглэгээ хийх, авто замын их засварын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Д.Батцэцэг

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүд:

Г.Энххишиг

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Ц.Энхжаргал

(Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГазрын дарга)

Хөндлөнгийн төлөөлөл:

Ө.Наранчулуун

(Сүмбэр сумын 3 дугаар багийн иргэн)

Нарийн бичгийн дарга:


Б.Болд-Эрдэнэ

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Д.Батцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаж эзэмшил ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д. Содном)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Засаг дарга
Г. Батцамбаяр

Г.БАТЗАМ